

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Баянгол сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СЭА-2026/002/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх Утас:7036-3040 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
Сүхбаатар сум 2026 он	Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 7036-3036 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn Аудитор: Ч.Сугардорж Утас: 7036-2442 Цахим хаяг: sugardorjch@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

БАЯНГОЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Н.ДАВААНЯМ ТАНАА

2026.03.23 № СЭА-2026/002/НА-СТА-ТТЗ

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Баянгол сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянгол сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Баянгол сумын ИТХ-ын "Сумын 2025 оны тодотгосон төсөв батлах тухай" 34 дүгээр тогтоолоор тайлант онд 2,096,232.8 мянган төгрөгийн татварын орлого, 471,900.0 мянган төгрөгийн татварын бус орлого зэрэг нийт 2,568,132.8 мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 3,005,707.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 11.7 хувь буюу 437,574.8 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь

СЭА-2026/002-НА-СТА-ТТЗ

харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2,218,731.7 мянган төгрөгийн жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга, аймгийн замын сангийн хөрөнгө оруулалтаар 59,811.0 мянган төгрөгийн зам засвар, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 1,685,068.1 мянган төгрөгийн зам гүүрний байгууламж зэрэг хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Баянгол сумын Засаг дарга нь тайлант онд 5 зорилт, 159 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 93.8 хувийн хэрэгжилттэй тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ

22.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Эхний үлдэгдэл	2. Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,489,684.88	4,054,808.85
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,736,703.02	2,686,887.51
33	АВЛАГА	196,390.27	167,660.18
35	БАРАА МАТЕРИАЛ	1,556,591.59	1,200,261.15
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,389,744.29	9,433,842.97
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,389,744.29	9,433,842.97
39200	Биет хөрөнгө	5,280,806.14	9,161,256.82
39300	1Биет бус хөрөнгө	108,938.15	272,586.15
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	8,879,429.17	13,488,651.82
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	74,770.55	451,160.5
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	74,770.55	451,160.5
41300	Өглөг	74,770.55	451,160.5
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,804,658.62	13,037,491.33
51	Засгийн газрын хувь оролцоо	8,804,658.62	13,037,491.33
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,264,860.61	1,264,860.61
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	7,273.1	7,273.1
51200	Хуримтлагдсан үр дүн	6,055,886.88	10,270,114.58
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,476,638.03	1,495,243.03
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	8,879,429.17	13,488,651.82

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансын код	Дансны нэр, төрөл	1. Өмнөх он	2. Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	5,900,241.19	7,403,952.62
11	ТАТВАРЫН ОРЛОГО	2,251,162.41	2,546,516.22
110	Орлогын албан татвар	1,714,345.05	1,913,085.33
1100	Хувь хүний орлогын албан татвар	1,809,267.87	2,051,429.26
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-94,922.82	-138,343.92
113	Хөрөнгийн албан татвар	241,056.78	238,453.68

118	Бусад татвар, төлбөр, хураамж	295,760.58	394,977.21
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,735,055.68	4,857,436.39
122	Тусламжийн орлого	0.0	45,841.18
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,914,023.1	0.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,738,031.9	2,812,191.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,738,031.9	2,672,547.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,681,518.72	2,594,167.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	999,792.79	1,231,637.57
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	109,951.59	112,474.39
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	549,781.34	579,217.31
2104	Хангамж, бараа материалын зардал	64,495.52	67,790.63
2105	Нормативт зардал	2,100	3,989.86
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	81,806.22	96,549.27
2107	Томилолт, зочны зардал	6,385.3	5,644.13
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	215,826.74	112,149.24
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	651,379.21	384,714.97
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	56,513.18	78,380.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	139,643.45
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	3,162,209.29	4,591,761.61
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,111,588.49	375,761.39
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	-1,111,588.49	-375,761.39
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	2,050,620.8	4,216,000.22

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,754,037.82	6,754,037.82
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,754,037.82	6,754,037.82
3	Тайлант үеийн үр дүн	2,050,620.8	2,050,620.8
9	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,804,658.62	8,804,658.62
10	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	8,804,658.62	8,804,658.62
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-10,742.87	-10,742.87
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,793,915.75	8,793,915.75
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	8,970.35	8,970.35
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	18,605	18,605
19	Тайлант үеийн үр дүн	4,216,000.22	4,216,000.22
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	13,037,491.33	13,037,491.33

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Өмнөх он	2. Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	4,951,045.59	5,160,277.42
11	ТАТВАРЫН ОРЛОГО	2,251,162.41	2,546,516.22
110	Орлогын албан татвар	1,714,345.05	1,913,085.33
1100	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-94,922.82	-138,343.92
113	Хөрөнгийн албан татвар	241,056.78	238,453.68
118	Бусад татвар, төлбөр, хураамж	295,760.58	394,977.21
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	19,184.8	38,068.15
1181	Газрын төлбөр	275,805.45	356,265.84
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	770.33	643.22
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	759,729.75	2,613,761.19
120	Нийтлэг татварын бус орлого	759,729.75	661,526.62
122	Тусламжийн орлого	0.0	41,748.18
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	1,910,486.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,940,153.43	0.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,310,469.4	2,463,189.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,310,469.4	2,463,189.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,253,756.22	2,384,809.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,061,840.39	1,304,755.97
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	127,431.95	112,474.39
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	553,440.42	582,766.6
2104	Хангамж, бараа материалын зардал	94,416.63	92,942.28
2105	Нормативт зардал	2,100	3,989.86
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	67,321.5	101,549.27
2107	Томилолт, зочны зардал	6,385.3	5,644.13
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	228,899.87	71,575.94
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	111,920.16	109,110.76
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	56,713.18	78,380.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,640,576.19	2,697,088.03

V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	1,816,918.47	1,668,407.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,816,918.47	1,668,407.6
2200	Дотоод эх үүсвэрээр	1,816,918.47	1,668,407.6
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-1,816,918.47	-1,668,407.6
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	30,000	40,000
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	0.0	38,495.93
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-30,000	-78,495.93
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	793,657.72	950,184.5
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	943,045.29	1,736,703.02
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,736,703.02	2,686,887.51

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Төлөвлөгөө	2. Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	5,524,330.2	5,021,364.3	502,965.9	90.9
11	Татварын орлого	2,096,232.8	2,546,516.2	(450,283.4)	121.5
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	1,367,233.6	1,837,347.0	(470,113.4)	134.4
110002	Үйл ажиллагааны орлого	126,952.3	38,428.2	88,524.1	30.3
110003	Хөрөнгийн орлого	275,700.0	147,242.8	128,457.2	53.4
110004	Хөрөнгө борлуулсны орлого	18,240.0	28,411.3	(10,171.3)	155.8
110101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(138,344.0)	(138,343.9)	(0.1)	100.0
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	90,839.0	125,676.3	(34,837.3)	138.4
113002	Бууны албан татвар	1,500.0	1,320.0	180.0	88.0
113004	Малд ногдуулах албан татвар	100,000.0	111,457.4	(11,457.4)	111.5
118001	Улсын тэмдэгтийн хураамж	4,100.0	3,622.7	477.3	88.4
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	1,815.7	602.0	1,213.7	33.2
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	40,000.0	33,843.4	6,156.6	84.6
118101	Газрын төлбөр	156,964.4	305,039.4	(148,075.0)	194.3
118102	Дуудлага худалдаа	50,000.0	51,226.4	(1,226.4)	102.5
118201	Ойн нөөц ашигласны төлбөр	193.8	-	193.8	-

118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	638.0	-	638.0	-
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	-	426.1	(426.1)	-
118204	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	400.0	217.1	182.9	54.3
12	Татварын бус орлого	2,604,490.9	2,474,848.1	129,642.8	95.0
120003	Торгуулийн орлого	435,500.0	382,182.2	53,317.8	87.8
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	17,068.0	72,770.2	(55,702.2)	426.4
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	5,000.0	3,813.0	1,187.0	76.3
120009	Бусад орлого	31,400.0	73,196.2	(41,796.2)	233.
122003	Аймаг нийслэлээс авсан татаас	32,400.1	32,400.1	-	100.0
122005	Төсвөөс санхүүжих-Эхний үлдэгдлээс	823,606.5	-	823,606.5	-
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	2,083,122.8	1,910,486.4	172,636.4	91.7
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,524,330.2	4,039,985.3	1,484,344.9	73.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,868,412.2	2,331,577.7	536,834.5	81.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,787,232.0	2,253,197.5	534,034.5	80.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,395,738.9	1,230,608.6	165,130.3	88.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	174,467.4	112,356.1	62,111.3	64.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	608,196.6	579,217.3	28,979.3	95.2
2104	Хангамж, бараа материалын зардал	63,142.2	51,548.7	11,593.5	81.6
2105	Нормативт зардал	4,910.0	3,989.9	920.1	81.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	112,961.0	101,549.3	11,411.7	89.9
2107	Томилолт, зочны зардал	12,500.0	5,644.1	6,855.9	45.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	188,455.0	69,125.9	119,329.1	36.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	226,860.9	99,157.7	127,703.2	43.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	81,180.2	78,380.2	2,800.0	96.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	81,180.2	78,380.2	2,800.0	96.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,459,218.0	1,668,407.6	790,810.4	67.8
220001	Барилга байгууламж	2,053,257.2	1,235,965.5	817,291.7	60.2
221001	Их засвар	124,460.8	120,143.5	4,317.3	96.5
222001	Тоног төхөөрөмж	124,500.0	206,648.2	(82,148.2)	166.0
223001	Бусад хөрөнгө	157,000.0	105,650.4	51,349.6	67.3
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	196,700.0	40,000.0	156,700.0	20.3
230001	Эргэж төлөгдөх зээл	196,700.0	40,000.0	156,700.0	20.3
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	981,379.0	-	-
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	981,379.0	-	-

7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	981,379.0	-	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,669,940.9	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,615,655.0	-	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр

№	Дансны код	Дансны нэр, төрөл	1. Тайлант он
1	1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	24,348,414.2
2	12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	24,348,414.2
3	122	Тусламжийн орлого	24,348,414.2
4	1221	Хандив тусламж /дотоод/	24,348,414.2
5	12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	24,348,414.2
6	350013	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	674,649
7	350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,018,617
8	350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	17,655,148.2
9	II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,517,027
10	21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,517,027
11	210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,517,027
12	2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,029,000
13	210101	Үндсэн цалин	1,029,000
14	2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	118,335
15	210201	Тэтгэврийн даатгал	72,030
16	210202	Тэтгэмжийн даатгал	8,232
17	210203	ҮОМШӨ-ний даатгал	2,058
18	210204	Ажилгүйдлийн даатгал	15,435
19	210205	Эрүүл мэндийн даатгал	20,580
20	2104	Хангамж, бараа материалын зардал	4,369,692
21	210402	Тээвэр, шатахуун	4,189,692
22	210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	180,000
23	2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	400,000
24	210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	400,000

25	2109	Бараа үйлчилгээний бусад зардал	600,000
26	210901	1 Бараа үйлчилгээний бусад зардал	600,000
27	4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	17,831,387.2
28	5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-17,831,387.2
29	6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-17,831,387.2

3.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитын явцад нягтлан бодох бүртгэлтэй холбоотой нийт 2,183.0 мянган төгрөгийн залруулаагүй алдаанд¹ зөвлөмж өглөө. Үүнд:

Залруулаагүй алдаа:

- ЗДТГ нь **2,183.0** мянган төгрөгийн урсгал засварын зардлыг капиталжуулсан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*” гэсэн заалт болон УСНББОУС-1 “*Санхүүгийн тайлангийн толилуулга агуулга*”-ийн 27-д “*Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой...*”, санхүүгийн тайлангийн “*Үнэлгээ ба хуваарилалт*” батламж мэдэгдлийг хангахгүй байна

Өгсөн зөвлөмж: Урсгал засварын зардлыг капиталжуулсан алдааг 2026 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд залруулах, ажил гүйлгээг холбогдох стандарт, заавар, журмын дагуу үнэн зөв бүртгэж, бүртгэл тайланд тусгаж байх.

Аудитаар нийт **370,497.8** мянган төгрөгийн зөрчил² илэрснээс **9,414.9** мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлэн, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх **361,082.9** мянган төгрөгийн зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар **1,952.0** мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс **9,414.9** мянган төгрөгийн залруулагдаагүй материаллаг зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс **17,582.2** мянган төгрөгөөр бага тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

3.1 Албан шаардлага:

ЗДТГ:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжихээр батлагдсан “Гэр хорооллын гудамжинд хатуу хучилттай зам тавих ажлын зураг төсвийг хийлгэж ажлыг эхлүүлэх” төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч болох “Мажестик Солюшн Рөүд” ХХК-тай 746,364.3 мянган төгрөгийн гэрээ байгуулахдаа санхүүжилтийн явц удааширсан тохиолдолд захиалагч талаас хоног тутамд 0.5 хувиар алданги тооцох орон нутагт хохиролтой гэрээ байгуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*”, 16 дугаар зүйлийн 16.5.2 дахь “*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Орон нутагт хохиролтой тул гэрээний тусгай нөхцөлд өөрчлөлт оруулах албан шаардлага хүргүүлэв.

2. Сумын орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 2 төсөл арга хэмжээний **1,729.8 мянган** төгрөгийн магадалшгүй ажлын зардлыг акт, хурлын тэмдэглэл, төсөв зэрэг анхан шатны баримтгүй олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*”, 13.7 дахь “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*”, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “*Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам*”-ын 4.8.17-д “*Магадалшгүй ажлын зардлыг барилгын гүйцэтгэгч, захиалагч байгууллагууд харилцан тохиролцсон актын дагуу зураг төсөлд тусгагдаагүй ажлыг санхүүжүүлэхэд зарцуулах бөгөөд уг зардлыг хурлын тэмдэглэл, магадалшгүй ажлын төсөв, баримтжуулсан фото зураг болон гүйцэтгэл, холбогдох норм, дүрэмд заасныг үндэслэн Барилгын төсөв зохиох дүрэмд заасан хавсралтын дагуу баталгаажуулан ирүүлснийг үндэслэн олгоно*” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөл, арга хэмжээний магадалшгүй ажлын зардлыг анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр санхүүжүүлж байх албан шаардлага хүргүүлэв.

3. Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалт бусаар буюу хур хог хаягдал, орчны бохирдолд **2,400.0 мянган** төгрөгийн хөрөнгө зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйл “*Нөөц хөрөнгийн зориулалт*”-ын 2.1.1-2.1.6 дугаар заалтууд болон 2.1.5: “*Энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээ*”, 1.2 дахь “*... урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан гэдгийг жил бүр давтагддаггүй онцгой арга хэмжээ, тохиолдлыг ... гэж ойлгоно.*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэв.

4. Баянгол сумын "Баянгол сувилал" ААТҮГ нь анхан шатны баримтгүйгээр **2,146.1 мянган** төгрөгийн шатахуун зарцуулж, бүртгэл тайланд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан,*

мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг тус зөрчсөн байна

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил, гүйлгээг бүртгэл тайланд тусгаж байх албан шаардлага хүргүүлэв.

5. ЗДТГ нь өөрийн орлогын төлөвлөгөөг **1,187.0 мянган** төгрөгөөр тасалсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

3.2 Зөвлөмж:

1. Анхан шатны баримттай холбоотой

Илрүүлэлт: Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжихээр батлагдсан хөрөнгө оруулалтын санхүүжилтийг олгохдоо хяналтын хуудас, ажлын гүйцэтгэлийн маягт зэрэг баримтын бүрдэл дутуу баримтаар санхүүжилт олгосон.

Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.3 дахь “Гүйцэтгэлийн санхүүжилт, түүний ангилал, бүрдүүлэх материал” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Зөвлөмж: Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн санхүүжилтийг олгохдоо журмын дагуу материалыг бүрэн бүрдүүлсний дараа олгож байх

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал:

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 77 нэр төрлийн 361,082.9 мянган төгрөгийн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, актлах болон цаашид ашиглах эсэх саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлж шийдвэрлүүлээгүй байна. Үүнд:

- ИТХ нь 36 нэр төрлийн 22,598.1 мянган төгрөгийн;
- ЗДТГ нь 41 нэр төрлийн 338,484.8 мянган төгрөгийн.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох” гэсэн заалттай нийцэхгүй, УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн ХЗУ³4-д “... байгууллага

³ ХЗУ-Хэрэгжүүлэх заавар удирдамж

нь тухайн хөрөнгийг уг тайлангийн өдрөөр түүний одоогийн бодит үнэ цэнээр дахин үнэлэх хэрэгтэй ...” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч ашиглаж байгаа хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох болон актлах эсэх саналыг бэлтгэн, холбогдох газарт хүргүүлэн шийдвэрлүүлэх.

Дээрх **зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг** Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5⁴-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

⁴ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
ЗДТГ	1	2,183.0			1	2,183.0			1	2,183.0	1	2,183.0
Дүн	1	2,183.0			1	2,183.0			1	2,183.0	1	2,183.0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ТТЗ	4	4,129.8			3	4,129.8	1	0				
ИТХ								22,598.1				
ЗДТГ	2	362,269.9			1	1,187.0	1	338,484.8				
Баянгол сувилал ААТҮГ	1	2,146.1			1	2,146.1						
Сумын ТТЗ-ийн дүн	7	368,545.8			5	7,462.9	2	361,082.9				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Нийт 24 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1						1	
Дүн	1						1	
ТБОНӨХБАҮХАТ хуулийн хэрэгжилттэй холбоотой								
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой								
ТТЗ	1	1,452.0			1	1,452.0		
ИТХ		500.0				500.0		
Нийт дүн	1	1,952.0			1	1,952.0		